

*Х.Анхбаяр - ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн 8042
дугаар дамжааны суралцагч, хошууч
Я.Ариунболд — ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн Хилийн албаны удирдлага, стратегийн
профессорын багийн профессор, хурандаа*

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН СУРГАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

***Хураангуй:** Энэхүү нийтлэлээр Хил хамгаалах байгууллагын тусгай
мэргэжлнт цэргийн алба хаагчдын сургалтыг боловсронгуй болгоход оршино.*

***Түлхүүр үг:** Цэргийн сургалт, сургалтын хэрэгцээ тодорхойлох.*

Оршил: Монгол Улсын шинэ Үндсэн хууль (1992)-д улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэхээ даяар олноо зарлан тунхаглаж: “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн гэж заажээ. Энэ үүргийг биелүүлэхэд төрийн байгууллагын тогтолцооны онцгой хэлбэр-хил хамгаалах байгууллагын өөрчлөлт шинэчлэлт онцгой ач холбогдолтой юм.

Хилчдийн гүйцэтгэх үүргийн онцлог, албаны ачаалал бие бүрэлдэхүүний онолын болон бие бялдар, сэтгэлзүйн хангалтын түвшин, сүүлийн үед гарч буй хилийн зөрчлийн шинж чанар, цаашдын хандлага зэрэг нь хилчдийн сургалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсронгуй болгохыг зүй ёсоор шаардаж байна.

Өнөөдөр Хил Хамгаалах Байгууллагын хэмжээнд явагдаж буй сургалтын үр дүнд, дүн шинжилгээ хийхэд тусгай мэргэжлийн офицер ахлагч нартай явуулах сургалтын тогтолцоог шинэчлэх, сургалтын хэлбэрийг өөрчлөх, албаны болон мэргэжлийн онцлогийг харгалзан үзэх асуудлууд зайлшгүй үгүйлэгдэж байгаа нь энэхүү сэдвийг сонгон судлах үндэслэл болсон.

Нэг.Цэргийн сургалтын онол арга зүйн тухай онолын ойлголт

Сургалтын онол, арга зүй түүний учир холбогдлын тухай ойлголт

Мэдлэг олгох үйл нь хүн төрөлхтний түүхтэй хамт урт цаг хугацаанд хөгжин ирсэн бөгөөд “...неолит буюу шинэ чулуун зэвсгийн үед...өсвөр үеийнхээ хүүхдүүдийг өдөр тутмын ажил, амьдралын практикт дагуулж, оролцуулдаг...”

Дээд сургуулийн сурган хүмүүжүүлэх зүй. байснаас эхлэн сургалтын хөгжлийн түүхийг судлаачид эхлүүлсэн гэж тооцдог байна. Улмаар хүн төрөлхтөн нийгэмшиж, ажил хөдөлмөрийн хуваарь, бичиг үсэг үүсэж, хүүхэд

багачуудыг харилцан ялгаатай зүйлд сургах шаардлага бий болсноор "...МЭӨ IV зууны үед анхны сургууль үүссэн..."

Харин дэлхий дахинаа сургалтын талаарх шинжлэх ухаанч сэтгэлгээ XV зууны эхэн үеэс бүрэлдэн тогтсон бөгөөд тухайн үеийн Сэргэн мандалтын үеийн сурган хүмүүжүүлэгчид гэж нэрлэгддэг "...Витторин ба Фельтте, ФрансуаРобле, МишельМонтено, ЭразмРаттердамский, ТомасМор нар номчирхохуй шашны сургаалын суртлын үндсийг халж оронд нь хүүхдүүдийг тоо. газарзүй, түүх болон бусад амьдралд чухал бодит зүйлстэй танилцуулан шашны бус утга зохиол судлуулахын чухлыг зааж..." [Ардын боловсролын яам. Сургалтын онолын үндэс эхэлсэн цагаас орчин үеийн боловсролын онол, шинжлэх ухаанч сургалтын технологийн хөгжлийн суурь тавигдсан байна.

Монгол Улс нь "Мэдлэгт суурилсан" хөгжлийн чиг хандлагыг сонгосон бөгөөд Хил хамгаалах байгууллага ч уг зарчмын дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж явуулах нь зайлшгүй болоод байгаа юм. Энэ нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал баримт бичгийн 1,2,4 дэх хэсэгт "...Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна..." гэж зааснаар баталгаажсан байдаг.

Хоёр. Монгол Улсын цэргийн боловсролын тогтолцооны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага

Монгол Улсын цэргийн сургалтын тогтолцоо нь Монгол Улсын боловсролын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг мөн. Уг тогтолцоо нь Монгол Улсын үндэсний эрх ашиг, аюулгүй байдал, тусгаар тогтнолыг хангахад үйлчилдэг бөгөөд Монгол Улсын Боловсролын тухай хууль /2002 оны 05 дугаар сарын 03-ны/-ийг мөрдлөг болгодог.

Тиймээс уг тогтолцоо нь Монгол Улсын боловсролын үндсэн зарчим, агуулга, удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг дагаж мөрддөг. Онцлог нь, "бүх нийтийн ерөнхий боловсрол" эзэмшсэн иргэдэд дипломын өмнөх, бакалаврын, магистрын, докторын боловсролын зэрэг эзэмшүүлдэг.

Монгол Улсын цэргийн боловсролын тогтолцооны үйл ажиллагаа нь иргэдийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын өндөр чадавхтай. хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай, бие бялдар, сэтгэл зүйн өндөр бэлтгэлтэй цэргийн мэргэжилтэн болгон төлөвшүүлдэг. Боловсорч гарсан цэргийн боловсролын бүх шатны бүтээгдэхүүн нь эх орноо батлан хамгаалах үйл хэргийг дэлхийн ямар ч улс орны цэргийн мэргэжилтнээс харьцангуй илүү чадварлагаар залгамжилж ирсэн онцлогтой. Үүнийг өнөөдөр олон улсын цэргийн ажиллагаанд оролцож буй офицер, ахлагч нар дэлхий нийтэд батлан харуулсаар байна.

Монгол Улсын цэргийн боловсролын тогтолцоо нь хөгжингүй орнуудын цэргийн боловсролын тогтолцоотой өрсөлдөхүйц чадвартай болох хөрс суурь нь эрх зүйн хувьд хэдийнээ тавигдсан гэж үзэж болох юм. Үүнийг нэгд, Монгол Улсын шинэ үеийн боловсролын бодлого, түүний зарчмуудыг Монгол Улсын "Боловсролын тухай", "Их дээд боловсролын тухай", "Мэргэжлийн боловсролын тухай" хуулиудад баталгаажуулснаар, хоёрт, Монгол Улсын цэргийн боловсролын үйл ажиллагааны үр дүн олон олон улсын хэмжээнд нэр хүндтэй байгаагаар тайлбарлаж болох юм.

Цэргийн боловсролын тогтолцоо нь "албан боловсрол"-ыг сургалтын албан ёсны байгууллага буюу цэргийн их, дээд сургуулиар, "албан бус боловсрол"-ыг цэргийн их, дээд сургуулийн курс, дамжаа болон анги байгууллагын дэргэдэх бэлтгэл сургалтаар дамжуулан олгох үйл ажиллагаа явуулж байна.

Цэргийн албан боловсролын агуулгыг дотор нь дипломын өмнөх, бакалаврын, магистрын, докторын гэж дөрвөн төвшинд ангилж байна. Эдгээр төвшин тус бүрийн агуулгыг Монгол Улсын Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд заасны дагуу тус тус тодорхойлж, боловсролын улсын стандартаар нарийвчлан тогтоосон байна. Энэ нь Монгол Улсын цэргийн боловсролын тогтолцоог бүтцийн хувьд үзвэл, албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд иргэний болон цэргийн мэргэжлийн дээд боловсролоос бүрдмэл байна.

Цэргийн боловсролын тогтолцоонд "албан боловсрол"-ын агуулга, стандартыг хуульд заасан журмын дагуу тогтоосон бөгөөд албан бус боловсролын агуулга стандарт буюу цэргийн мэргэжлийн тусгай боловсролын хөгжлийн чиг хандлага нь цэргийн шинжлэх ухаан-технологийн хөгжил, дайн зэвсэгт мөргөлдөөн, цэргийн урлагийн онол, бүтэц, зохион байгуулалт, үүрэг зориулалттай нягт уялдаж, байнгын чөлөөтэй хөгжиж, нээлттэй явж ирсэн байна.

Гурав.Хил хамгаалах байгууллагын сургалтын өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ

Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдал нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны чухал чиглэл бөгөөд улсын хил хамгаалалтын амжилт нь дээр дурдсанчлан "...мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээ..."-д суурилах нь тодорхой юм. Тиймээс улсын хилийн халдашгүй дархан байдлыг хилийн орон зайд хэрхэн хангах нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд шууд нөлөөлөх бөгөөд энэхүү үүргийг ХХБ-ын үндсэн нэгж болох Хилийн отряд гүйцэтгэдэг.

ХО-ын сургалтыг 2009 оноос “Сургалт бэлтгэл хөтөлбөрийн” хүрээнд ХХЕГ-ын штабаас сургалт зохион байгуулах зааврыг боловсруулан жил бүр ХО-дад хүргэж бие бүрэлдэхүүний сургалтыг явуулж ирсэн бөгөөд сургалтын үр дүн, туршлага сургамжид тулгуурлан “Сургалт бэлтгэл 2016” хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэхэд бэлэн болоод байна. Сургалт зохион байгуулах зааврын дагуу ХО-ын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг тухайн хичээлийн жилийг календарийн хугацаагаар тооцон ХО-ын даргын 02 тоот тушаал гаргах замаар зохион байгуулж явуулдаг. ХХБ-ын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг 1-4 дүгээр сар хүртэл 1 дүгээр үе, 7-10 сар хүртэлх хугацаанд тус тус 2 үе болгон зохион байгуулдаг нь ХХБ-ын үйл ажиллагаа, улсын хил хамгаалах эрх ашигт нийцүүлсэн онцлог болж байгаа юм.

ХХБ-ын бие бүрэлдэхүүний сургалт нь УХХ-д шаардлагатай бүхэнд сургах зарчимд тулгуурлан явагдах бөгөөд сургалтад хамрагдаж байгаа бүрэлдэхүүнээс хамаарч сургалтыг дараах байдлаар ялгамжтай тогтоодог. Үүнд:

1. Албаны болон цагийн байдлын өрнөлтийн үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл олгох сургалт;
2. Штабын бэлтгэл;
3. ХХЕГ-ын бие бүрэлдэхүүний бэлтгэл сургалт;
4. ХО-ын бие бүрэлдэхүүний бэлтгэл сургалт тус тус болно.

Албаны болон цагийн байдлын өрнөлтийн үед үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах сургалтыг цагийн байдлын ямар ч нөхцөлд тавигдсан үүргийг амжилттай гүйцэтгэх, НҮБ-ын Энхийг дэмжих, террорист үйлдлийн эсрэг сөрөг тусгай ажиллагаа болон томилгоот бүлгүүд, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан ажиллах чадварыг дээшлүүлэх зорилготой бөгөөд ХХЕГ-ын даргын бэлтгэл хүч, томилгоот бүлгүүдийн хүрээнд явуулж, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн хэлтэс, албадын мэргэжилтнүүдийг татан оролцуулах хэлбэрээр зохион байгуулдаг.

Штабын бэлтгэлийг албаны болон цагийн байдлын өрнөлтийн үед үүрэг гүйцэтгэх ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, удирдаж явуулахад удирдлагыг оновчтой мэдээллээр хангах холбогдох тооцоо, шийдвэр, ажиллагааны хувилбаруудыг боловсруулах дадлага. ур чадвар олгоход чиглүүлэн ХО-ын даргын удирдлагаар бүлгийн дасгал, штабын хэсэгчилсэн болон нэгдсэн дадлага, Команд штабын сургууль (цаашид КШС гэх)-аар зохион байгуулагдаж байна.

ХХЕГ-ын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг хууль, дүрэм, удирдлагын баримт бичиг, улсын хил хамгаалалтын арга, хэрэгсэл, туршлага.

сургамж, цэргийн удирдахуйн ухааны хөгжлийн талаар мэдлэг олгох чиглэлээр явуулж байна.

ХО-ын "Сургалт бэлтгэл" гэсэн нэр томъёог ХХБ-ын хэмжээнд албаны бичиг баримтад тусгасан байдаг. Энэхүү агуулгыг бүрэн нээн гаргах зайлшгүй шаардлагатай юм. "Сургалт". "Бэлтгэл" гэсэн харилцан ялгаатай агуулгаас бүрдэж байгаа бөгөөд Монгол хэлний тайлбар тольд "Бэлтгэл" гэдэг нь "...бэлдвэр, урьдчилан бэлдсэн юм..." гэсэн байна. Тэгэхлээр УХХ ажиллагаанд ХО-ыг албаны хувьд урьдчилан бэлдсэн байх гэсэн агуулгатай болох нь тодорхой харагдаж байна. Тиймээс ХО-ын хэмжээнд явагдаж байгаа бие бүрэлдэхүүний сургалт нь тухайн отрядын албаны бэлтгэлийн бүрэлдэхүүн хэсэг болох нь зайлшгүй юм.

ХО-ын бие бүрэлдэхүүний сургалтыг хүн нэг бүрийн бэлтгэлийн хүрээнд лекц семинар, бие даалт, бүлгийн дасгал болон сургалтын бусад арга, хэлбэрээр онолын мэдлэг эзэмшүүлэх, бататгах, Бүлгийн бэлтгэлийн хүрээнд бүлгийн бүрэлдэхүүнд албаны болон цагийн байдлын өрнөлтийн үед үүрэггүйцэтгэхчадварыгхөгжүүлэх, ХО, заставын буюу салбарын жигдрэлтийн хүрээнд хүн нэг бүрийн бэлтгэл, бүлгийн жигдрэлтийн явцад олсон мэдлэг, дадлагыг бататгах, хилийн застав, отрядын дараах бие бүрэлдэхүүнд албаны болон цагийн байдлын өрнөлтийн үед албаныүүрэг гүйцэтгэх чадварыг хөгжүүлэх чиглэлээр тус тус сургалтыг зохион байгуулж байна. Үүнд:

1. Хилийн застав, харуулын сургалт бэлтгэл;
2. Офицер, ахлагч нарын сургалт бэлтгэл;
3. Гэрээт хилчдийн сургалт бэлтгэл;
4. Хугацаат цэргийн алба хаагчдын сургалт бэлтгэл;
5. Бусад сургалт бэлтгэл тус тус болно.

ХО-ын сургалтыг лекц, семинар, бүлгийн дасгал, штабын хэсэгчилсэн болон нэгдсэн дадлага, КПС гэсэн сургалтын хэлбэрүүдийг ашиглан явуулж байгаа бөгөөд 2010, 2011, 2012 оны хичээлийн жилүүдэд ХО-ын сургалтыг "Хилийн отрядын хариуцсан хэсэгт улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах", "Хилийн эрэл зохион байгуулах, түүний урьдчилсан ажиллагааны төлөвлөгөө боловсруулах аргачлал", "Зэвсэгт халдлагыг няцаах отрядын ажиллагаа" гэсэн бүлэг сэдвийн хүрээнд зохион байгуулан явуулсан байна.

Хилийн отрядын сургалт бэлтгэлийг зохион байгуулж, явуулах, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахад чиглэсэн үр дүн нь дээр дурдсанчлан сургалтын технологитой шууд хамааралтай юм. Ялангуяа сургалтын хэлбэрийг хэрхэн ашиглах талаар ХХБ-ын сургалт бэлтгэл хөтөлбөрт дараах байдлаар тусгайлан заасан байна. Үүнд:

Тусгай мэргэжлийн цэргийн алба хаагчдын сургалтыг боловсронгуй болгох арга зам. /Хилийн.....дугаар ангийн жишээн дээр/

Ангийн төвд 85 алба хаагч ажиллаж байгаагаас Цэргийн мэргэжлийн дээд сургууль төгссөн 18 алба хаагч ажилладаг.

Цэргийн дээд боловсролтой албан тушаалтны эзлэх хувь

Цэргийн ухааны бакалавр 6%

Хил судлалын ухааны бакалавр 44%

Командын Хил магистр судлалын ухааны магистр 11% 39%

Цэргийн дээд боловсролтой албан тушаал...

Цэргийн мэргэжилтний эзлэх хувь

Ар талын мэргэжи

лтэн 6%

Захирагч, орлогч 22%

Штабын мэргэжи лтэн 44%

Даргын зөвлөлийн гишүүд 28%

Цэргийн ухааны магистр зэрэгтэй

Штаб, ар талын мэргэжи лтэн 25%


Даргын зөвлөлийн гишүүд 25%

Захирагч, орлогч 50%

Цэргийн ухааны бакалавр

даргын зөвлөл 33%

Штаб, ар талын мэргэжи лтэн 67%



Хилийн дугаар ангид цэргийн дээд боловсролтой албан тушаалтан 18, энгийн дээд боловсролтой 17, тусгай дунд боловсролтой 50 албан хаагч байгаагаас цэргийн дээд боловсролтой албан хаагчийн эзлэх хувь хэмжээ нь 21.17 хувь, энгийн их дээд сургууль төгссөн алба хаагчид 20 хувь, тусгай дунд боловсролтой албан хаагч 58.8 хувь, тусгай мэргэжилтэн нийт 78,8 хувийг эзэлж байгаа нь ангийн сургалт бэлтгэлийг тусгай мэргэжилтэнд рүү төвлөрүүлж, тэдний цэргийн хэргийн мэдлэг болон, биеэр хийж гүйцэтгэх албаны мэдлэгийг сайжруулахын тулд шат дараалсан сургалтын арга хэмжээг хэрэгжүүлэн сургах шаардлага зүй ёсоор гарч байна.

Хил хамгаалах байгууллагаас дэвшүүлсэн зорилтын ач холбогдлыг манай хамт олон цаг үеэ олсон, хүний хөгжлийг дээдэлсэн, гарах үр дүн нь байгууллага хувь хүний үйл ажиллагаанд эергээр нөлөөлөх олон төрлийн ач холбогдолтой, цаашид ч улам баяжуулж төгөлдөржүүлж авч явах тасралтгүй хэрэгжих бололцоотой зөв ажил хэмээн тодорхойлж байна.

Өмнөх жилүүдийн болон “Сургалт бэлтгэл хөтөлбөр” сургалтын хөтөлбөрийн дагуу ангийн бие бүрэлдэхүүнийг “Зуун хувь” цэргийн чиглэлийн сургалтад хамруулдаг байсан.

Тэрхүү сургалтын хөтөлбөр тэр тусмаа манай ангийн төрөл мэргэжлийн боловсон хүчний мэргэжлийн ур чадварт сөрөг үр дагавартай байгааг харгалзан мэргэжлийн сургалт 30, цэргийн сургалтыг 70 хувийн харьцаагаар явуулснаар мэргэжлийн хувьд тодорхой хэмжээнд ахиц гаран дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхэд ахиц гарах явдал юм.

Иймд ангийн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөр төлөвлөгөө, заах арга зүй, шалгах шалгуур үзүүлэлт, тухайн шалгагдаж буй алба тасгийн шалгалтыг мэргэжлийн хэлтсээс нь тухайн чиглэлээр нь мэргэжлийн хүмүүс нь шалгадаг тогтолцоог бий болгосноор бидний явуулж буй сургалт аль аль талдаа үр өгөөжөө өгсөн бодит сургалт болох юм.

Жишээ 1: Барилгын засал хийдэг хүн барилгыг ямар технологиор тухайн ажлыг ямар чанартай хийж байгаа нь тухайн хүнийг шалгах шалгалт, хийсэн ажлыг нь үнэлэх үнэлэмж байх болохоос тухайн хүн хил хамгаалалтын дүрэм, буудлагын дасгал, бусад цэргийн мэдлэгээр хангалтгүй дүн үзүүлсэн нь тухайн хүний хийсэн ажлыг үгүйсгэх үндэс болох учиргүй юм.

Жишээ 2: Улаанбаатар хотын доторх хөдөлгөөнд үйлчилгээнд оролцогч жолооч замын хөдөлгөөний дүрэм, хийж буй ажлын онцлог, үйлчилгээ үзүүлэх ёс зүй, дүрэм журам зэргийг нарийн мэддэг байх нь чухал. Тухайн хүн хотын доторх хөдөлгөөнд оролцож чадах ч хүн байна чадахгүй хүн ч байдаг, эзэмшсэн машин нь 1980-аад оны УАЗ-452 машин /бидний хэлж заншсанаар аавын чээж/ шатахуун зарцуулалт их, маневрлах чадвар муу, ачаа даах чадвар хангалтгүй, өглөө ажилд гарлаа үдийн хойно л нэг юм арай гэж ирнэ. Зам дээр эвдэрч гэмтэнэ зогсоно, түгжээ үүснэ хүмүүс элдвээр хэлдэг. Тухайн жолооч бусадтай маргаж муудалцвал эргээд байгууллагын талаар сөрөг сурталчилгаа, мэдээлэл болоод ирнэ. Тэгэхлээр мэргэжлийн талаас нь хувь хүний соёл талаас сургалтыг чиглүүлэх шаардлага амьдралаас урган гарч байгаа явдал их байна.

Жишээ 3: ХАА-н ажилтан мал сүргийн ашиг шим үр өгөөжийг зөв зохистой ашиглах чиглэлээр ямар ажил зохиосон, бие бүрэлдэхүүн үүнээс ямар үр ашиг хүртсэн, өөрөө ямар чиглэлээр сурч аж ахуйн өсөлт, мал сүргийн

үүлдэр угсааг хэрхэн сайжруулсан талаар мэргэжлийн дагуу ажлыг түлхүү шалгадаг чиглэлд анхааръя.

Хил хамгаалах байгууллагын байнгын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг 3 шаттай явуулж байна.

- Албаны мэргэжил эзэмшүүлэх: Хилийн алба, Хууль эрх зүй, Галын бэлтгэл, Ерөнхий цэргийн эрдэм. Цэргийн байр зүйн хичээлээр;

- Жигдрэлтийг хангах: Цэргийн дүрэм, Жагсаалын бэлтгэл, Биеийн тамирын хичээлийг **40 хувийг** онолоор. **60 хувийг** дадлагаар;

- Мэргэшүүлэх: Хил хамгаалалтын тактик, **төрөл, тусгай** мэргэжлийн бэлтгэл. Гадаад хэл, Тусгай бэлтгэлийн хичээлийг **30 хувийг** онолоор, **70 хувийг** дадлагаар **батлагдсан төлөвлөгөөний** дагуу тус тус зохион байгуулж, дэвшүүлсэн зорилтын хүрээнд хилчдийн цэргийн мэргэшлийн түвшнийг дээшлүүлэх, “Хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүнтэй явуулах сургалт бэлтгэл” хөтөлбөрт бие бүрэлдэхүүний ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг биелүүлэхэд шаардлагатай цэргийн хэргийн мэдлэг олгох, албаны стандартыг хангах, ур чадварыг дээшлүүлэх шаардлага байгаа юм.

Дүгнэлт

Хилчдийн сургалт бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох ажлаа бид, олон жилийн турш сургалт явуулж ирэхдээ “хил хамгаалахад хэрэгтэй бүхэнд сургана” гэж ерөнхийлөн тунхаглаж, хил хамгаалахад хэрэгтэй чухам юунд сургах гээд байгаагаа тодорхойлохгүй, зүгээр л сургана сургана гэж ярьсаар, ярьснаараа сургалт явж байна гэж бодсоор, сургалтад ёс төдий хандаж ирснээ, түүнд төдийлөн ач холбогдол өгдөггүй байснаа, өнөөдөр ч өгөхгүй байгаагаа хаана, хаанаа хүлээн зөвшөөрөхөөс эхлэх ёстой гэсэн дүгнэлтэд хүрэв.

Сургалт бэлтгэлийг төрөл мэргэжлийн онцлогийг алба тус бүрд нь тохируулж хэрэгжүүлснээр төрөл мэргэжлийн алба хаагчдын мэргэжлийн ур чадвар сайжирч, дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн, анги байгууллагын өмнөө тавьсан зорилт хүлээсэн үүрэг биелэгдэхэд ихээхэн чухал ач холбогдолтойгоос гадна үр нөлөө нь хувь хүний цаг зав. сурах нөхцөл бололцоо, эрмэлзлэл нэмэгдэх, байгууллагад эдийн засгийн хэмнэлт, өөрчлөлт хөгжил, тогтсон арга барил, мэргэжлийн бодит өрсөлдөөн, харилцан туршлага солилцоо, үнэлгээний зөв шударга тогтолцоо бүрдэнэ гэж үзэж байна. Хилийн отрядын албаны бэлтгэл сургалт нь эрэлт хэрэгцээнд тулгуурласан шинж чанараараа чадваржуулах /цогц чадамж олгох/ буюу прагматик, хилийн аюулгүй байдалд нөлөөлөх гадаад дотоод хүчин зүйлсийн хувьсалд зохицох шинэчлэлт онолын мэдлэг өндөр мэдлэг тулгуурлах хэрэгцээ нь академик сургалтын шинжийг хослуулсан хэлбэртэй байх онцлогтой байна.

Үүнээс гадна манай улсын иргэний их, дээд сургуульд цэргийн гаднах сургалтын тогтолцоо байхгүй тул цэргийн хэргийг дэлхийн шинжлэх ухаантай холбох үүрэгтэй эсвэл дайны бус цэргийн ажиллагааг хүмүүнлэгийн аргаар зохицуулах чадвартай “байгалийн болон техникийн ухааны цэргийн мэргэжилтэн”-ийг бэлтгэх ямар ч бололцоогүй байна.

Хил хамгаалах байгууллага 2009 оноос эхлэн “Сургалт бэлтгэл” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ирсэн ба сүүлийн 4 жилийн хугацаанд сургалт бэлтгэлийг эрчимжүүлэх, бие бүрэлдэхүүний албаны ур чадвар, манлайллынтүвшнийг дээшлүүлэх, талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирсэн.

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд тусгай мэргэжлийн офицер ахлагч нийт бие бүрэлдэхүүний 30% буюу 2500 гаруй цэргийн алба хаагчид улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах ажилд өөрийн мэргэжил боловсролоо зориулан ажиллаж байна.

Өмнөх жилүүдийн болон “Сургалт бэлтгэл хөтөлбөр” сургалтын хөтөлбөрийн дагуу ангийн бие бүрэлдэхүүнийг “Зуун хувь” цэргийн чиглэлийн сургалтад хамруулдаг байсан.

Тэрхүү сургалтын хөтөлбөр тэр тусмаа манай ангийн төрөл мэргэжлийн боловсон хүчний мэргэжлийн ур чадварт сөрөг үр дагавартай байгааг харгалзан мэргэжлийн сургалт 30, цэргийн сургалтыг 70 хувийн харьцаагаар явуулснаар мэргэжлийн хувьд тодорхой хэмжээнд ахиц гаран дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхэд ахиц гарах явдал юм.

Сургалт бэлтгэлийг дээр дурьсанчлан төрөл мэргэжлийн онцлогийг алба тус бүрт нь тохируулж хэрэгжүүлсэнээр төрөл мэргэжлийн алба хаагчдын мэргэжлийн ур чадвар сайжирч, дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн, анги байгууллагын өмнөө тавьсан зорилт хүлээсэн үүрэг биелэгдэхэд ихээхэн чухал ач холбогдолтойгоос гадна үр нөлөө нь хувь хүний цаг зав, сурах нөхцөл бололцоо, эрмэлзлэл нэмэгдэх, байгууллагад эдийн засгийн хэмнэлт, өөрчлөлт хөгжил, тогтсон арга барил, мэргэжлийн бодит өрсөлдөөн, харилцан туршлага солилцоо, үнэлгээний зөв шударга тогтолцоо бүрдэнэ.

“Хил хамгаалах байгууллагын тусгай мэргэжлийн цэргийн алба хаагчдын сургалтыг боловсронгуй болгох нь” сэдэв судалгаар дэвшүүлсэн дээрх дүгнэлт тулгуурлан Хилийн отрядын албаны бэлтгэл сургалтыг боловсронгуй болгох дараах санал байна. Үүнд:

1. Тусгай мэргэжлийн цэргийн алба хаагчдын сургалтыг үндсэн үүрэг болон, албаны онцлог, мэргэжлийг нь харгалзан үзэж сургалтыг явуулах;

2. Тусгай мэргэжлийн цэргийн алба хаагчдыг тухайн мэргэжлийн сургалт, судалгааны ажлыг явуулж буй Төрийн байгууллагуудтай хамтран бүсчилсэн болон алсын зайны сургалтын хэлбэрээр явуулах;
3. Албанд дадлагажуулах сургалтыг Хилийн сургууль дээр түшиглэн зохион байгуулах

Санал зөвлөмж

1. Тусгай мэргэжлийн цэргийн алба хаагчдын сургалтыг үндсэн үүрэг болон албаны онцлог, мэргэжлийг нь харгалзан үзэж сургалтыг явуулах
2. Тусгай мэргэжлийн цэргийн алба хаагчдыг алсын зайны сургалтад хамруулах
3. Албанд дадлагажуулах сургалтыг Хилийн сургууль дээр түшиглэн зохион байгуулах
4. Сургалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах
5. Мэргэжлээр нь ажиллуулах